

УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны Байнгын хорооны саналаар хийсэн аудитын тайлан



“Үдийн цай” хөтөлбөрийн явц, үр дүн

**“ҮДИЙН ЦАЙ” ХӨТӨЛБӨРИЙГ “ҮДИЙН ХООЛ”
БОЛГОН ӨРГӨЖҮҮЛЭХ НӨХЦӨЛ БҮРДЭЭГҮЙ
БАЙНА**

АГУУЛГА

<p><u>Тайланг бэлтгэсэн:</u></p> <p>ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газар</p> <p>Газрын захирал: Д.Ганбилэг</p> <p>Аудитын менежер: Х.Баярмаа</p> <p>Ахлах аудитор: Ц.Гэрэл С.Сэрчхорол Д.Болормаа</p> <p>Аудитор: З.Ариунзаяа П.Цэнгүүн</p> <p>Шинжээч: Ж.Эрдэнэ Л.Авирмэд Д.Нямхүү Д.Баттулга Д.Энхболд</p> <p>2011 оны 6 дугаар сар</p> <p>Уг тайланг ҮАГ-ын Веб сайт-аас үзнэ үү. www.mnao.mn</p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261885 дугаарын утас, 323266 дугаарын факс, mnao@mnao.mn имэйл хаягаар харилцана уу</p>	<p>Товчилсон үгсийн жагсаалт</p>	3
	<p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....</p>	4
	<p>Бүлэг 1: “Үдийн цай” хөтөлбөр нийгэмд зохих үр дүнгээ өгч байна</p>	6
	<ul style="list-style-type: none"> • <i>Ерөнхий зүйл</i> 	6
	<ul style="list-style-type: none"> • <i>Оролцогч талуудын талуудын ажлын уялдаа холбоог зохицуулсан эрх зүйн орчин хангалтгүй байна</i> 	6
	<ul style="list-style-type: none"> • <i>Үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлснээр нааштай үр дүн гарч байгааг судалгааны дүн харуулж байна</i> 	7
	<ul style="list-style-type: none"> • <i>Сурлагын чанарт ахиц гарсан эсэхийг харьцуулах үзүүлэлт алга байна</i> 	9
	<p>Бүлэг 2 :“Үдийн цай” хөтөлбөрийг “Үдийн хоол” болгон өргөжүүлэх нөхцөл бүрдээгүй байна</p>	11
	<ul style="list-style-type: none"> • <i>“Үдийн хоол” хөтөлбөр хэрэгжүүлэх бэлтгэл бүрэн хангагдаагүй байна</i> 	11
	<ul style="list-style-type: none"> • <i>Хүнсний бүтээгдэхүүний чанар, илчлэг, орц, нь стандартын шаардлага хангахгүй байна</i> 	12
<ul style="list-style-type: none"> • <i>Хоол хүнсний аюулгүй байдал, орчны эрүүл ахуй, ариутгал халдваргүйтэл хангалтгүй байна</i> 	15	
<ul style="list-style-type: none"> • <i>Зарим сургуульд лабораторийн шинжилгээний дүгнэлтгүй бэлэн бүтээгдэхүүн олгож байна</i> 	16	
<ul style="list-style-type: none"> • <i>Орон нутагт бүтээгдэхүүний тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаж байна</i> 	17	
<p>Бүлэг 3: Хөтөлбөрийн хэрэгжилтийг хөдөлмөр эрхлэлт, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх төрийн бодлоготой уялдуулах боломж байна</p>	19	
<ul style="list-style-type: none"> • <i>Ерөнхий зүйл</i> 	19	

ХАЯГ:

Үндэсний аудитын газар
Чингэлтэй дүүрэг, Бага
тойруу-3, Засгийн газрын
IV байр
Улаанбаатар хот 15160
Монгол улс

<ul style="list-style-type: none">Ихэнх сургууль хүүхэд өдрийн гүйцэтгэлийг бодитой тооцдог, төрийн сангаас санхүүжилтийг гүйцэтгэлээр олгодог болсон байна	19
<ul style="list-style-type: none">Хөтөлбөрийг хөдөлмөр эрхлэлт, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх төрийн бодлоготой уялдуулах боломж байна	20
<ul style="list-style-type: none">Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй аж ахуйн нэгжид хариуцлага тооцоогүй байна	21
<ul style="list-style-type: none">Зарим сургууль хяналтын комисс байгуулаагүй байна	22
<ul style="list-style-type: none">Орон нутагт мэргэжлийн байгууллагууд хяналтаа хамтран хэрэгжүүлж байна	23
<ul style="list-style-type: none">БСШУЯ хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийгээгүй байна	24
Дүгнэлт:	25
Холбогдох байгууллагын санал	26
ҮАГ-ын тайлбар	28
Зөвлөмж:	29
Монгол Улсын Ерөнхий Аудиторын тушаал	30

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
НЭМХ	Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн
УИХ	Улсын Их Хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОУБ	Олон улсын байгууллага
СХЗТ	Стандарт хэмжил зүйн төв
СБД	Сүхбаатар дүүрэг
СХД	Сонгино хайрхан дүүрэг
ТББ	Төрийн бус байгууллага
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХААЖДҮГ	Хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЧД	Чингэлтэй дүүрэг
ХУД	Хан-Уул дүүрэг
ЭМН	Эрүүл мэндийн нэгдэл
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитыг УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны Байнгын хорооны санал, Монгол Улсын Ерөнхий аудитор Үндэсний аудитын газраас 2011 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт

“Үдийн цай” хөтөлбөрийн явц, үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Энэ зорилтын хүрээнд дараахь чиглэлээр аудит хийв. Үүнд:

- Үдийн цай хөтөлбөрийн төлөвлөлт, санхүүжилт, тайлагнал, хяналт оновчтой байгаа эсэх.
- Эрүүл ахуйн шаардлага хангахуйц бүтээгдэхүүн нийлүүлэгдэж байгаа эсэх.
- Үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлснээр чанарын ахиц, үр дүн гарсан эсэх.

Хамарсан хүрээ

Аудитад Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам болон аймаг нийслэлийн Боловсрол, соёлын газар, ерөнхий боловсролын зарим сургуулийн 2010 оны байдлаархи санхүү, үйл ажиллагааны тайлан, холбогдох судалгаа материал хамрагдав.

Арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам, гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу дараахь арга зүйг ашиглав. Үүнд:

- “Үдийн цай” хөтөлбөрт хамрагдах сурагчдын тооны гүйцэтгэлийг төлөвлөсөн бүртгэлтэй харьцуулах, санхүүжилтийн тооцоолол, хэмнэлт хэтрэлтийн талаар дүн шинжилгээ хийх, бэлтгэн нийлүүлэлтийн тооцоог нийлүүлэгчтэй хийсэн гэрээтэй тулган шалгах,
- Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас ирүүлсэн тайлан мэдээг судалж үнэлэлт, дүгнэлт хийх,
- Хөтөлбөрийн үйл ажиллагаанд оролцогч талуудын хамтын ажиллагааг судалж дүн шинжилгээ хийх,
- Хөтөлбөрийн үр дүнд сурагчдын бие бялдарын өсөлт, хөгжил, сурлагын чанарт ахиц гарсан эсэхийг судлах,
- Хөтөлбөрийн үр дүнгийн талаар болон “Үдийн хоол” хөтөлбөр болгон өргөжүүлэх урьдчилсан нөхцөл хангагдсан эсэх талаар судлах, ерөнхий боловсролын сургуулиудын захирал, эмч, анги даасан багш нар болон холбогдох хүмүүстэй ярилцлага хийж, тайлбар тодруулга авах,

- Нийслэлийн СХД, БГД, ЧД, ХУД-ийн 30 сургуульд “Үдийн цай” хөтөлбөрөөр сурагчдад олгож буй хүнсний бүтээгдэхүүнээс дээж авч НЭМХ-гээр лабораторийн шинжилгээ болон хоолны цэсэнд үнэлгээ хийлгэх,
- “Үдийн цай” болон “Үдийн хоол” хөтөлбөрийн талаархи олон улсын жишиг судлах.

Аудитын явцад “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгийн талаар эцэг эх, багш нараас санал асуулга авч нэгтгэн дүн шинжилгээ хийв. Үүнд:

- Санал асуулгын хамрах хүрээг улсын хэмжээнд тархаан нэлэнхүй түүврийн аргаар УБ хотын 9 дүүрэг, 21 аймгийг хамруулсан.
- Аймаг, орон нутагт сумыг сонгохдоо аймгийн төвд хамгийн ойр байршилтай болон аймгийн төвөөс хамгийн алслагдмал байршилтай сумаас мэдээллийг авахаар тооцсон нь үдийн цайны бүтээгдэхүүн нийлүүлэлт, тээвэрлэлтийн онцлогт илрэх шинжийг тодорхойлох зорилгыг агуулсан.
- Квот түүврийн аргаар тухайн сонгогдсон сумд (аймгийн төв нь 1 сумаар тооцоологдсон) байрлах ЕБС-ийн 50 хувийг санал асуулгад хамруулсан. Мөн судалгааны объектоор сонгогдсон тухайн сургуулийн бага ангийн багш нарын 30-аас доошгүй хувь, эцэг эхийн 5 хүн тутмын нэгийг хамруулахаар тооцсон нь санал асуулгын дүн түүврийн төлөөллийн хувьд Монгол Улсын хэмжээнд тархаан ойлгоход хангалттай төлөөлөл болж чадсан.
- Санал асуулгад улсын хэмжээний нийт 9059 бага ангийн багшийн 2668 буюу 29.4 хувийг, нийт эцэг эхийн 5.5 хувь буюу 5585 хүн хамрагдав.

Аудитын багийн бүрэлдэхүүн

Аудитыг УАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газрын болон аймаг, нийслэлийн аудитын газрын аудитор, шинжээчид гүйцэтгэж, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн Хоол судлалын төв, түүний харъяа төв лабораторитой хамтарч ажиллав.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн шалгалтын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Бүлэг 1

“Үдийн цай” хөтөлбөр нийгэмд зохих үр дүнгээ өгч байна

Ерөнхий зүйл

1.1 “Тэтгэмж, мөнгөн тусламжийн хэмжээг тогтоох тухай” УИХ-ын 2006 оны 47дугаар тогтоол, уг тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай УИХ-ын 2006 оны 66 дугаар тогтоол, “Хөтөлбөр хэрэгжүүлэх тухай” МУЗГ-ын 2006 оны 194, 2008 оны 45 дугаар тогтоолуудыг үндэслэн “Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

1.2 “Үдийн цай” хөтөлбөрт 2006 оны сүүлийн хагас жилд 1-2, 2007 онд 1-4, 2008 оноос 1-5 дугаар ангийн сурагчдыг хамруулсан байна.

1.3 2010-2011 оны хичээлийн жилд “Үдийн цай” хөтөлбөрт 257.7 мянган хүүхэд хамрагдаж байгаа нь нийт сурагчдын 51.9 хувийг эзэлж байна.




Оролцогч талуудын ажлын уялдаа холбоог зохицуулсан эрх зүйн орчин хангалтгүй байна

- 1.4 “Үдийн цай” хөтөлбөрийн баримт бичгийг боловсруулж, батлаагүйгээс түүний хэрэгжих болсон шалтгаан, үндсэн зорилго, дэд зорилт, хүрэх түвшин, хэрэгжилтийг тооцох шалгуур үзүүлэлт тодорхойгүй байна.
- 1.5 Засгийн газрын 2006 оны 194 дүгээр тогтоолоор “Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлэхийг БСШУ-ны сайдад, хүнсний бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн шаардлага, орчны ариун цэврийн талаар хяналт тавихыг Мэргэжлийн хяналт эрхэлсэн сайдад (хуучин нэрээр) даалгасан, харин ЭМЯ, ХХААХҮЯ болон орон нутгийн засаг захиргааны хүлээх үүргийг тодорхойлоогүй байна.
- 1.6 Ийнхүү хөтөлбөрийн хэрэгжилтэд оролцогч талуудын хүлээх үүрэг хариуцлагыг эрх зүйн актаар зохицуулаагүйгээс холбогдох төрийн байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагаа, ажлын уялдаа, мэдээллийн солилцоо хангалтгүй байна.
- 1.7 БСШУ-ны сайд, ЭМ-ийн сайдын 2006 оны 379/341 дүгээр тушаалаар батлагдсан “Үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд мөрдөх журам”-д бэлтгэн нийлүүлэлт, хяналт, хариуцлагын тогтолцоо оновчтой бус, төлөвлөлт, тайлагналын асуудлыг орхигдуулсан байна.

Үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлснээр нааштай үр дүн гарч байгааг судалгааны дүн харуулж байна


1.8 “Үдийн цай” хөтөлбөр бага ангийн сурагчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн, хүүхдийн ирц сайжрах нэг хөшүүрэг болж байгаа нь багш, эцэг эхээс авсан санал асуулгын дүнгээс харагдаж байна.

“Үдийн цай” хөтөлбөр хэрэгжсэнээр ахиц дэвшил гарсан эсэх талаар багш нараас авсан санал асуулгын дүнг графиктаар харуулбал,



1.9 Санал асуулгад оролцсон 3 багшийн нэг нь үдийн цай хөтөлбөр хэрэгжсэнээр хичээлийн ирц сайжирсан, 4 багшийн нэг нь орлого багатай өрхийн төсөвт мэдэгдэхүйц дэм болж байгаа, 5 багшийн нэг нь сургууль завсардалт буурахад нөлөөлсөн, харин 10 багшийн нэг нь хичээлийн идэвхи, сурлагын чанар дээшлэхэд тодорхой нөлөөтэй байгаа гэж хариулсан байна.

Харин эцэг эхчүүд дээрх асуултад санал хэрхэн нийлж байгааг графиктаар харуулбал,



1.10 Эцэг эхчүүдийн 51.3 хувь нь буюу 2 эцэг эх тутмын нэг нь үдийн цай хөтөлбөр хэрэгжиж эхэлснээр сурагчдын сурах идэвхи, хичээлийн ирцэд ахиц гарсантай санал нийлж байгаа бол 3.5 хувь нь санал нийлэхгүй гэж хариулсан байна. Харин 45.2 хувь нь цаашид сайжруулах асуудлууд тодорхой хэмжээгээр байгаа гэсэн санал өгчээ.

1.11 Санал асуулгад оролцсон эцэг, эхчүүдээс өгсөн саналыг тэдний сарын орлогын түвшин, ажил эрхлэлттэй нь харьцуулан үзвэл оролцогчдын гэр бүлийн дундаж орлогоос үл хамааран эцэг эхчүүд хөтөлбөр хэрэгжсэнээр хүүхдүүдийн сурлагын чанар, хичээлийн идэвхи, ирцэд ахиц гарсан гэж үзжээ.

1.12 Хөтөлбөр хэрэгжсэнээр сурлагын чанарт ахиц гарсантай санал нийлэх эсэх талаархи асуултад эцэг эхчүүдийн орлогын түвшин нэмэгдэхийн хэрээр “огт санал нийлэхгүй” гэсэн хариулт бага зэрэг өсөх хандлагатай байгаа нь тухайн хөтөлбөр бага ангийн сурагчдын сурлагын чанар, идэвхид нөлөөлөхөөс гадна гэр бүлийн амьжиргаанд тус дэм болж байгааг давхар нотлон харуулж байна.

1.13 Аудитад 159.0 мянган сурагчид хамрагдсан нь нийт суралцагч 257.7 мянган хүүхдийн 60 орчим хувь болж байгаа юм.

1.14 Сурагчдын ирцэд судалгаа хийж үзэхэд 2007-2008 оны хичээлийн жилийн бага ангийн сурагчдын долоо хоногийн дундаж ирц 91.3 хувьтай байсан бол 2010-2011 хичээлийн жилд 96.7 хувь болж сурагчийн ирц 5.4 хувиар өссөн нь уг хөтөлбөр хүүхдийн сурах идэвхи, хичээлийн ирцэд сайн нөлөө үзүүлж байгааг харуулж байна.

1.15 Бага ангийн багш, сургалтын менежер, сургуулийн удирдлага, эцэг эхчүүдтэй хийсэн ярилцлага, уулзалтын дүнгээс үзэхэд ялангуяа нийслэлийн захын болон хөдөө орон нутгийн сургуулиудад орлого багатай өрхийн хүүхдийн хичээлийн ирц, хүүхдийн идэвхи өмнөх үеэс сайжирсан талаар дурдсан байна. Үүнийг нэгтгэж үзвэл дараахь өөрчлөлтүүд гарчээ.

- Хүүхдүүд хичээлдээ ирэх сонирхолтой болж, хичээл таслалт, сургууль завсардалт багассан;
- Сурагчдын өдөр тутмын ирц сайжирч хичээлд оролцох идэвхи нэмэгдсэн;
- Хичээлийн сүүлийн цагуудад бага насны хүүхдүүд ядарч анхаарал нь төвлөрдөггүй байсан бэрхшээл багассан;
- Хүүхдүүд өөртөө үйлчлэх зөв зан үйлд суралцаж, гараа угаах, соёлтой хооллох дадал хэвшилтэй болоход нааштайгаар нөлөөлж байна.

1.16 Харин холбогдох яамд ялангуяа БСШУЯ "Үдийн цай" хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн, үр өгөөжийг холбогдох үзүүлэлтээр нарийвчлан тооцох, харьцуулалт хийх, дүгнэлт өгөх тал дээр хангалтгүй ажиллаж, тайлан мэдээ гаргалт бүрэн бус байгаагаас яамны хэмжээнд нэгдсэн мэдээлэл алга байна.

1.17 Сургуулиудын үдийн цай өгөх цаг зөрүүтэй байгаагаас хичээлийн цагт сөргөөр нөлөөлөх, ирцийн нэгдсэн бүртгэлийн дэвтэргүйгээс харилцан адилгүй бүртгэж хяналт тавих боломжийг бууруулж байгаа нь Дундговь, Говьсүмбэр, Хэнтий болон **нийслэлийн зарим** сургуульд ажиглагдсан байна.

1.18 Мөн шинэ жил, цагаан сар, хүүхдийн амралт эхлэх, дуусах хугацаа 7 хоногийн дундуур таарах үед хүүхдийн ирц буурсан байдал хөдөө орон нутагт түгээмэл байна.

1.19 Бага ангиас хүүхэд завсардах байдал улсын хэмжээнд багассанд "Үдийн цай" хөтөлбөр нөлөөлсөн хэдий ч сургууль, сум, орон нутаг, яамны зүгээс албан бус сургалт, зайны сургалтад хамруулах, сурагчдын сургалт, хүмүүжлийн талаархи олон талт ажлын үр дүнтэй холбож үзэж болохоор байна.

1.20 Баян-Өлгий, Булган, Дорнод, Говьсүмбэр, Хэнтий, Сэлэнгэ, Сүхбаатар, Увс, Завхан аймгуудаас сургууль завсардалтын талаар тодорхой судалгаа гаргаж ирүүлээгүй ба бусад аймгуудын дүнгээр 2006 онд 1076 хүүхэд сургууль завсардаж байсан бол 2010 онд 422 болж 54.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

1.21 "Үдийн цай" хөтөлбөрт хамрагдсанаар сургууль завсардалт багассан гэж 16 аймгийн аудитын газраас ирүүлсэн тайланд дурдсан бол нийслэл болон 5 аймаг онцын нөлөөлөөгүй гэж дүгнэжээ.

Сурлагын чанарт ахиц гарсан эсэхийг харьцуулах үзүүлэлт алга байна

1.22 2005 оноос хойш БСШУЯ, Боловсролын хүрээлэнгээс улсын хэмжээнд сурлагын амжилтад хяналт шинжилгээ, үнэлгээ хийгээгүйн улмаас бага боловсролын түвшинд чанарын ахиц гарсан талаар улс, аймгийн дундажтай харьцуулсан үзүүлэлт алга байна.


1.23 Аудитад хамрагдсан сургуулиудын хүүхдийн сурлагын чанарт ахиц гарсан эсэх судалгааг аймаг, нийслэлээс нэгтгэн ирүүлсэн боловч улсын хэмжээнд харьцуулах үзүүлэлтгүйгээс шалтгаалан дүгнэлт өгөх боломжгүй байлаа.

1.24 Архангай, Баянхонгор, Булган, Говьсүмбэр, Ховд, Өмнөговь, Орхон, Сүхбаатар, Төв, Увс, Дорнод, Дундговь аймгууд, болон нийслэл Улаанбаатар хотод сурлагын чанарт ахиц гарсан гэж үзсэн байна. Тухайлбал,

- Ховд аймагт сурлагын чанар 2006 онд 58.2 хувь байсан бол 2010 онд 69.0 хувь болж өссөн;
- Нийслэлд 2-5-р ангийн сурагчдын хичээлийн жилийн эхэнд үзүүлсэн сурлагын амжилт жилийн дунд үзүүлсэн амжилтанд чанарын ахиц гарсан;
- Орхон аймагт “Үдийн цай” хэрэгжиж эхлэхээс өмнө бага боловсролын сурлагын стандарт хангалт 99.2 байсан бол 2009-2010 онд 99.8 хувьд хүрч өссөн;

1.25 Харин Завхан, Говь-Алтай, Сэлэнгэ, Хөвсгөл, Дархан-Уул, Баян-Өлгий, Хэнтий аймагт сурлагын чанарт төдийлөн их өөрчлөлт ороогүй гэсэн судалгаа гарчээ.

1.26 “Үдийн цай” хөтөлбөр хэр үр өгөөжтэй байгаа талаар сурагчдын эцэг эхчүүд дараахь хариултыг өгсөн байна. Үүнийг графикаар харуулбал,



1.27 Энэхүү хөтөлбөрийг цаашид үргэлжлүүлэх, өргөжүүлэх хэрэгцээ байгаа эсэх талаар санал асуулгад оролцогч эцэг эхчүүдийн 84.6 хувь тийм гэсэн хариулт өгснөөс дүгнэн үзэхэд тухайн хөтөлбөр ач холбогдолтой болох нь тодорхой байна.

1.28 Санал асуулгад эцэг эхчүүдийн санал нийлэхгүй гэсэн хариултыг ажил эрхлэлтийн байдалтай харьцуулахад төрийн захиргааны байгууллагын ажиллагсдын 20.4 хувь, инженер

техникийн ажилтнуудын 28.1 хувь нь шаардлагагүй гэж хариулжээ.

1.29 Харин ажилгүй иргэд 82.5, тэтгэвэр, группт байдаг хүмүүсийн 83.3, ажилчдын 84.8, малчдын 85.9 хувь, багш нарын 93.3 хувь нь үдийн цай хөтөлбөрийг өргөжүүлэн үргэлжлүүлэх хэрэгтэй гэсэн байр суурьтай байна.

1.30 Тус хөтөлбөр хүмүүсийн амьжиргаанд тодорхой хэмжээгээр нөлөөлдөг болох талаар эцэг эхчүүдийн 80.3 хувь “Үдийн цай” хөтөлбөр манай өрхийн амьжиргаанд тодорхой хэмжээгээр тус дэм болж байна гэж хариулснаар нотлогдож байна.

Олон улсын жишээ:

АНУ-ын Засгийн газар 1932 оноос илүүдэл ургацын бүтээгдэхүүнийг хүүхдэд өгч эхэлснээс өдрийн хоолны эхлэл тавигдсан байна. Одоогоор сургуулиудын үдийн хоол хөтөлбөр нь дараах 3 шатлалаар хэрэгждэг байна. Үүнд:

- Амьжиргааны баталгаажих түвшингийн 130 хувиас доош орлоготой өрхийн хүүхдэд үнэгүй хоол,
- 130-185 хувийн хооронд өрхийн орлого нь хэлбэлздэг айлын хүүхдүүдэд хямдралтай хоол,
- 185 хувиас дээш өрхийн орлоготой айлын хүүхдүүд бүтэн үнээр нь хоол иддэг байна.

Англи улсад өрхийн орлогод үндэслэн улсаас өрхийн орлогын, ажилгүйдлийн тэтгэмж авч буй гэр бүлийн хүүхдүүд үнэгүй үдийн хоол идэх эрх үүсдэг байна.¹

¹ Эдгээр улсын боловсролын яамдын цахим хуудас

“Бүлэг 2

“Үдийн цай” хөтөлбөрийг “Үдийн хоол” болгон хөгжүүлэх нөхцөл бүрдээгүй байна

2.1 Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд “Үдийн цай” хөтөлбөрийг “Үдийн хоол” болгон өргөжүүлэх, сургуулийн хоолны газар, дотуур байрны гал тогоог зориулалтын тоног төхөөрөмжөөр хангах, “Үдийн хоол” хөтөлбөр хэрэгжүүлэх журам батлан мөрдүүлэхээр тус тус заасан.

2.2 БСШУ, ЭМ, ХХААХҮ-ийн сайдын 2009 оны 244/173/129 дүгээр тушаалаар “Үдийн хоол” хөтөлбөр хэрэгжүүлэх талаар судлан санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, хөтөлбөрийн төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлээд байна.

2.3 Архангай аймгийн Хүмүүн 2 дугаар сургууль, Булган аймгийн Дашинчилэн сумын сургууль, нийслэлийн Сүхбаатар дүүргийн 58 дугаар сургуулиудад Монгол-Солонгосын хамтарсан “Шим тэжээл судлалын төв”-ийн төслийн, Төв аймгийн Алтанбулаг сумын сургуульд Тайландын вант улсын төслийн санхүүжилтээр “Үдийн хоол” хөтөлбөрийн туршилт хийж байна.

2.4 Дээрх төслүүдээс сургуулийн гал тогооны тоног төхөөрөмж, байрны тохижилтод 70-160 орчим сая төгрөг зарцуулж байгаа бөгөөд улсын хэмжээнд энэ жишгээр хэрэгжүүлнэ гэвэл ихээхэн хөрөнгө шаардагдахаар байна.

2.5 2009 онд БСШУЯ, НЗДТГ, НБГ, ШУТИС-ийн Хүнс, биотехнологийн сургуулийн харъяа шим тэжээл судлалын төвөөс “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн хамтарсан судалгаагаар нийт сургуулийн 75.6 хувь нь халуун хоолны үйлчилгээнд ямар нэг хэлбэрээр шилжсэн дүн гарсан, ихэнх сургуулиуд долоо хоногийн 2-4 өдөрт халуун хоол олгож, гол төлөв мантуун бууз, гурвалжин буюу хөц будаатай шөл, хуурга, ногооны зутан, бантан өгч байгаа ба санал асуулгад оролцсон эцэг эхчүүдийн 40.5 хувь нь халуун хоол, цай өгөхийг дэмжсэн байна.



2.6 Гэвч улсын хэмжээнд нийт сургуулийн 31.1 хувь гал тогоогүй, 68.9 хувь гал тогоотой боловч ихэнх нь түрээсээр ажилладаг, хүчин чадал, тоног төхөөрөмж, хоолны заалны багтаамж, хүрэлцээ хангалтгүй, аяга, таваг ариутгах, хадгалах, нөхцөл бүрдээгүй байна.²

2.7 Олон улсын жишгийн дагуу сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг “Сургуулийн хоолзүйч” мэргэжилтэн

2. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний нэгдсэн гал тогооны талаарх бодлогын санал. ШУТИС. Хүнсний инженер, биотехнологийн сургууль, Монгол- Солонгосын хамтарсан шим тэжээл судлалын төв. 2010. Х5

2. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилт. Шим судлалын төв. 2009. х 13

удирдан зохион байгуулдаг бөгөөд манай улсын хувьд ШУТИС-ийн Хүнс-технологийн сургуульд 2005 оноос дээрх мэргэжилтэнг бэлтгэж эхэлсэн ч зөвхөн Булган аймгийн Дашинчилэн, Архангай аймгийн “Хүмүүн”, нийслэлийн 58 дугаар сургуулиудад л ийм мэргэжилтэн ажиллаж байна.

Хүнсний бүтээгдэхүүний чанар, илчлэг, орц нь стандартын шаардлага хангахгүй байна

2.8 “Үдийн цай” хөтөлбөр хэрэгжсэнээр хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжилтөд үзүүлсэн нөлөөллийг судлах арга хэмжээг холбогдох яамдаас зохион байгуулаагүй байна.

2.9 БСШУ-ны болон ЭМ-ийн сайдын 2006 оны 379/341 дүгээр тушаалаар батлагдсан “Үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд мөрдөх журам”-д бэлтгэн нийлүүлэлт, үлгэрчилсэн цэс, авбал зохих илчлэгийн хэмжээг тодорхойлсон билээ.

2.10 Журамд дурдагдсан дээрх үзүүлэлтийг үдийн цайны бүтээгдэхүүнд хийсэн лаборотарийн шинжилгээний дүн болон санал асуулгад оролцогчдын дүгнэлтэд тулгуурлан авч үзвэл эцэг эхчүүдийн 559 буюу 10 хувь нь хөтөлбөр оновчгүй, үр дүнгүй хэрэгжиж байна гэж үзжээ.

2.11 Дээрх хүмүүсээс ямар учраас хөтөлбөр үр дүнгүй гэж үзсэн шалтгааныг тодруулахад 372 хүн буюу 66.5 хувь нь амт чанар, орц найрлага тааруугаас гэсэн хариулт өгчээ.

2.12 Эцэг эх, багш нар бүтээгдэхүүний чанарт ерөнхийд нь **дунд** гэсэн үнэлгээ өгсөн нь амт чанар, орц найрлага, бүтээгдэхүүний төрөл зүйл, хооллох орчны ариун цэвэр, эрүүл ахуйг сайжруулах хэрэгтэйг харуулж байна.

2.13 Энэ нь эцэг эх багш нарын дараахь дүгнэлтээр давхар нотлогдож байгаа болно.

№		Эцэг эх	Багш нар
1	Орц найрлага, илчлэг	3.78	3,79
2	Төрөл, зүйл	3.60	3,68
3	Өнгө үзэмж	3.74	3,75
4	Сав баглаа боодол	3.62	3,77
5	Хооллож буй орчин	3.75	3,75

Үдийн цайны бүтээгдэхүүний чанар, орчны үнэлгээ, дундаж үнэлгээгээр (маш сайн -5, маш муу -1)

2.14 Хүснэгтээс харахад, эцэг эх, багш нарын үнэлгээ үндсэндээ зөрүүгүй бөгөөд дээрх асуудлыг үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зайлшгүй анхаарах шаардлагатай байна.

2.15 Аудитын явцад хоол болон бэлэн бүтээгдэхүүнд хийсэн лабораторийн дээжийн шинжилгээний дүнгээс харахад “Үдийн цай”-гаар авах шаардлагатай илчлэг, уураг, өөх тос, нүүрс ус зэрэг шимт бодисын хэмжээ нь³ зохих норм стандарттай болон уг бүтээгдэхүүний шошгон дээр заасан үзүүлэлттэй ойролцоо

3. “Монгол хүний хоногийн хоол тэжээлийн физиологийн норм” (ЭМЯ, ХСТ, 2008) зөвлөмж хэмжээ болон БСШУЯ, ЭМЯ-ны хамтарсан БСШУ, ЭМ-ийн Сайдын 2006 оны 379/341 тоот тушаал ЕБС-ийн “Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлэх журам

байгаа боловч өөх тосны агууламж, нүүрс усны хэрэглээ харьцангуй их байна. Үүнийг хүснэгтээр харуулбал,

Сургуулийн нэр	Бүтээгдэхүүн/хоолны нэр	Шинжилгээний хариу			Хэвийн хэмжээ	
		Дээжийн нийт жин, гр	Өөх тос, гр	Илчлэг, ккал	Өөх тос, гр (эмэгтэй, эрэгтэй)	Илчлэг, ккал (эмэгтэй, эрэгтэй)
13 -р сургууль	Мантуун бууз	103.5	12.1	241.9	7.5- 9.0	270-325.5
37- р сургууль	Мантуун бууз	85.0	15.3	291.5		
78- р сургууль	Мантуун бууз	105.3	17.6	288.5		
Ирээдүй-1	Мантуун бууз	106.2	20.1	397.3		
52-р сургууль	Будаатай хуурга	113.5	15.4	256.7		
65-р сургууль	Будаатай хуурга	217.8	26.5	368.3		
17-р сургууль	Кекс	68.8	18.5	414.9		
37-р сургууль	Мишээл жигнэмэг	68.5	17.3	442.1		
38-р сургууль	жигнэмэг	59.3	13.5	305.4		
57-р сургууль	Самнай боов	60.6	26.1	457.2		
113-р сургууль	Нарийн боов	53.2	20.5	416.7		
Радуга	Цайны газрын боорцог	62.9	21.3	441.3		

2.16 Дээрх лабораторийн шинжилгээний дүнгээс үзэхэд “Үдийн цай”-нд өгч байгаа хоол, хүнсний бүтээгдэхүүнд амьтны гаралтай өөх тос буюу ханасан тосны илчлэг их байгаа нь цаашид таргалалт, чихрийн шижин зэрэг өвчин үүсгэх эрсдэлтэй юм.

2.17 Шинжилгээний дүнгээс үзэхэд “Үдийн цай”-гаар авах илчлэг, шимт бодисын хэмжээг ихэнх сургууль хангаж байна.


2.18 “Үдийн цай”-нд өгч буй халуун хоолны орц, найрлага, жин хэмжээ, боловсруулах аргачлал өөр байгаагаас нэг хүүхдэд ногдох илчлэг, эрдэс бодис харилцан адилгүй байна. Энэ нь хүүхдийн нас биеийн онцлогт тохирсон бэлэн бүтээгдэхүүн, халуун хоолны нэгдсэн **цэс, технологийн карт, стандарт** байхгүйтэй холбоотой байна.

2.19 Иймд бэлэн бүтээгдэхүүн нийлүүлэгч болон хоол хүнс үйлдвэрлэгч нарт хүүхдийн бие махбодийн онцлог, зохистой хооллолт, хоолны онцлогт тохирсон жор бүхий бүтээгдэхүүн хийх талаар сургалт хийх, гарын авлагаар хангах шаардлага гарч байна.

2.20 “Үдийн цай” хөтөлбөрт олгож байгаа зарим бүтээгдэхүүн шошгогүй, мөн шошго нь стандарт бус, бүтээгдэхүүний нэр, хадгалах нөхцөл, хугацаа нь тодорхойгүй байлаа. Үүнд,

- “Бенедакт” ХХК-ийн үзэм болон чацарганы жүүс, ундаа, “Коко десерт” ХХК-ийн нарийн боов,
- Дархан-Уул аймгийн нэгдүгээр сургууль, Булган аймгийн зарим сумд, Дундговь аймгийн Луус, Сайхан-Овоо, Цагаандэлгэр сумдад сав баглаа, боодолгүй боов олгосон байна

2.21 Санал асуулгад оролцогч багш нарын 15.8 хувь нь бэлэн бүтээгдэхүүн сав баглаа, боодолгүй байдаг гэж хариулжээ. Үүнийг графикаар харуулбал,



2.22 Сурагчдад олгож буй халуун хоолон дахь шимт бодисын лаборатори болон тооцооны аргаар шинжилсэн дүнг зөвлөмж хэмжээтэй харьцуулахад кальци фосфорын хэмжээ бага байна. Жишээ нь:

Будаатай хуурганы илчлэг, шимт бодисын харьцуулсан дүн

Үзүүлэлт	Зөвлөмж, хэмжээ (норм хэмжээ)		Лабораторийн шинжилгээний дүн	Тооцооны аргаар
	эрэгтэй	эмэгтэй		
Илчлэг (ккал)	325.5	270	368.3	238.37
Уураг	12.15	10.05	9.3	9.56
Өөх тос	9	7.5	26.5	4.66
Нүүрс ус	48.75	40.5	23.2	53.36
С (мг)	6.75	6.75	-	2.93
Кальци (мг)	120	120	1.1	10.91
Фосфор (мг)	75	75		82.9
Төмөр (мг)	1.2	1.2		2.22

2.23 Дээрх харьцуулсан судалгаанаас харахад кальцийн хэрэглээ нь зөвлөмж хэмжээнээс бага байгаа нь хүүхдэд ясны сийрэгжилт үүсэхэд нөлөөлж болзошгүй тул кальци, фосфорын харьцааг анхаарч, хоол хүнсний бусад микроэлемент, амин дэмийг судалж үзэх асуудал урган гарч байна.

2.24 “Хүнсний баталгаат байдал” Үндэсний хөтөлбөрийн 22.5 дахь заалтад... “Үдийн цай” хөтөлбөрийн хүрээнд олгож байгаа хүнсний тэжээллэг чанар, аюулгүй байдлыг сайжруулж, 60-аас доошгүй хувьд сүү, цагаан идээ хэрэглэдэг болох” (2009-2016) зорилт тусгагдсан боловч нийт сургуулийн дөнгөж 40 орчим хувь энэхүү хөтөлбөрийн заалтыг хэрэгжүүлж байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм. Иймд сүү, цагаан идээний хэрэглээнд анхаарлаа хандуулах шаардлагатай байна.

2.25 Нийслэлийн 52 дугаар сургуулийн 4^a ангийн сурагчдад шинжилгээ хийхэд 2-оос бусад нь ясны сийрэгжилттэй гарчээ.

2.26 Төв аймгийн ихэнх сургуулиуд орон нутгийн нөөц бололцоог ашиглан үхрийн нүд, чацарганы шүүс, аарц, ааруул, тараг, сүү цагаан идээ хэрэглэдэг жишиг тогтоод байна.

2.27 Хоолны цэсийн үнэлгээний дүнгээс үзэхэд стандартын шаардлага хангаагүй, нэр төрөл цөөн, давтамж олон, чихэрлэг гурилан бүтээгдэхүүн, жимсний шүүс давамгайлсан, сүү цагаан идээ, жимс жимсгэнэ бага хэрэглэж байгаа зэрэг нь хоол

хүнсээр авах шаардлагатай эрдэс бодисын хэмжээ, харьцаа алдагдахад нөлөөлж болзошгүй юм.

2.28 БСШУ, ЭМ-ийн сайдын 2006 оны 379\341 дүгээр тушаалаар батлагдсан “Үдийн цай”-ны цэс зохиоход хориглох бүтээгдэхүүний жагсаалтыг зөрчсөн дутагдал цөөнгүй илэрлээ. Тухайлбал,

- СХД-ийн “Ирээдүй” цогцолбор-1, БГД-ийн “102”, Баянхонгор аймгийн “Соого сейкео”, “Хөвсгөл аймгийн “Дэлгэрмөрөн” цогцолбор, Мөрөн сургууль, Тариалан, Их уул, Тосонцэнгэл, Рашаант, Бүрэнтогтох, Дорноговь аймгийн Замын Үүд, Иххэт, Алтанширээ сум, Сүхбаатар аймгийн ихэнх сургуульд чихэрлэг бүтээгдэхүүн;
- Хөвсгөл аймгийн Төмөрбулаг суманд бүтэн жилийн турш сүлжээний бүтээгдэхүүн болох гаа;
- Говь-Алтай, Баян-Өлгий аймагт гол төлөв гурилан бүтээгдэхүүн олгосон байна.

Олон улсын жишээ:

- Финлянд улсад үдийн цайны цэсэнд шинэ ногооны зууш, сүү, талх ордог бөгөөд малын болон загасны мах байдаг нь сурагчдын эрүүл мэндэд тустай, хүүхдүүд эцэг эхийнхээ амьдралын хэв маяг, орлогоос нь үл хамааран бүгд чанартай сайн хоол идэх боломж олгодог ажээ.
- Япон, АНУ, БНСУ-ын бага сургуульд хүүхдийн нас, биеийн жин, хүйс, бие махбодийн өсөлт хөгжил, хэрэгцээт шимт бодисын хэмжээг тодорхойлж, байгаль цаг уурын нөхцөлд нийцүүлэн үдийн цай, хоолоор үйлчилдэг байна

Хоол хүнсний аюулгүй байдал, орчны эрүүл ахуй, ариутгал халдваргүйтэл хангалтгүй байна

2.29 2010 онд гурван тохиолдолд 376 хүүхэд үдийн цайнаас хордсон нь хөтөлбөрт хамрагдсан нийт хүүхдийн (257.7 мянган хүүхэд хамрагддаг) 0.14 хувийг эзэлж байна.Тухайлбал,

- Нийслэлийн СБД-ийн Монгол-Оросын хамтарсан 3 дугаар сургуулийн цайны газрын пирожки, луувангийн салад;
- БЗД-ийн 53 дугаар сургуульд “Монсүү” ХК-ийн зөгийн балтай кальцитай сүү, хорхой ааруул;
- Ховд аймгийн Булган сумын сургуульд сумын нарийн боовны цехийн наполен тортноос тус тус хордсон байна.

2.30 Дээрх сургуулиудад хоол, хүнс үйлдвэрлэх, боловсруулах технологи болон ариун цэвэр, эрүүл ахуй, халдвар хамгааллын горим алдагдсан, төвлөрсөн захуудаас лабораторийн шинжилгээний дүгнэлттэй бүтээгдэхүүнээс авч хэрэглэсэн боловч хоолны хордлого үүссэн болохыг мэргэжлийн байгууллага тогтоожээ.

2.31 Судалгаанд оролцсон багш нарын 4.9 хувь үдийн цайны бүтээгдэхүүнээс шалтгаалан хоолны хордлогын шинжтэй хүндрэл гарсан, хориглосон бүтээгдэхүүн өгөх тохиолдол цөөн боловч гарч байсан гэж хариулжээ.

Зарим сургуульд лабораторийн шинжилгээний дүгнэлтгүй бэлэн бүтээгдэхүүн олгож байна

2.32 Бэлэн бүтээгдэхүүнийг гэрээт аж ахуйн нэгжээс шинжилгээний дүгнэлттэй авдаг боловч бусад түүхий эд, материал (мах, сүү, гурил, гурилан бүтээгдэхүүн)-ын гарал үүслийн гэрчилгээ, шинжилгээний дүгнэлтийг цаг тухайд нь авдаггүй байна. Тухайлбал,

- СХД-ийн Ирээдүй цогцолбор 2, БГД-ийн 102 дугаар сургуульд “Эвтэй намсрай” ХХК-ийн Амтлаг болон Дэлбээ боов, “Коко десерт” ХХК-ийн үзэмтэй кексийг олгож, СХД-ийн 107, БГД-ийн Эрдмийн ундраа 3 дугаар сургуулиуд шинжилгээгүй махаар хоол хийсэн;
- Дундговь аймагт 5 аж ахуйн нэгж, Дорноговь аймгийн Хөвсгөл сумын сургуульд нийлүүлэгдэж байгаа бүтээгдэхүүнийг шинжилгээнд хамруулаагүй;
- Хэнтий аймгийн Баянхутаг суманд орон нутгаас нийлүүлж буй бүтээгдэхүүний худалдан авалт бүрд шинжилгээний дүгнэлт авах боломжгүй, малын гаралтай бүтээгдэхүүнд урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан бичгээс өөр нотлох баримтгүй
- Өмнөговь аймагт бүтээгдэхүүнийг богино хугацаанд шинжилгээнд өгч чаддаггүй, шинжилгээний төлбөр төсөвт тусгагдаагүй байна.

2.33 Ихэнх сургуулийн эмч нар ариутгалын бодисыг үйлчилгээний ажилчдад найруулж өгдөг гэх боловч тэдэнд зориулсан сургалт, зааварчилга, зөвлөгөө дутмагаас ариутгалын бодисыг хэрэглэх талаарх мэдлэг сул байлаа.

2.34 Зарим сургуулийн цайны газрын ажилчид эрүүл ахуйн шинжилгээнд хамрагдаагүй, гар угаалгын болон ариун цэврийн өрөөнд хэрэглэж байгаа хлорамин, хлорын шохойн уусмалын найруулсан огноо, хугацаа байхгүй, чанарын шаардлага хангахгүй байна. Тухайлбал,

- Нийслэлийн Баянгол дүүргийн “Эрдмийн ундраа”, 54, 102, СХД-ийн “Ирээдүй цогцолбор-1”, Баянхонгор, Дархан- Уул аймгийн 19, 20 дугаар сургуулийг дурдаж болно.



2.35 Сургуулиудын гар угаалтуурын хүрэлцээг судлахад нэг угаалтуурт дунджаар 85 сурагч ногдож байгаа нь хэвийн хэмжээнээс 2 дахин их байна.

2.36 Зарим сургуульд санитол байхгүйгээс цэнэглэгч сав тогтмол ашиглагдахгүй, гол төлөв нойтон салфетка хэрэглэдэг, зарим эцэг эхчүүд тэр бүр авч өгч чаддаггүй, үдийн цай уух хугацаа богино тул гар угаах боломж муу байна.

2.37 Нийслэлийн сургуулиуд хортон шавьжийн устгалыг жилд 1-2 удаа мэргэжлийн байгууллагаар хийлгэдэг боловч зарим сургууль өөрийн хүчээр хийж

байгаа нь шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна.

2.38 Ихэнх сурагчид аяга, халбагаа тусгай уутанд хийж авч явдаг, цайны газрууд шаардлагын хэмжээнд сав, суулгаа 3 дамжлагаар угааж, ариутгадаггүйгээс ариун цэврийн шаардлага хангахгүй байна. Тухайлбал,

- Нийслэлийн СХД-ийн 107, Ирээдүй цогцолбор I бага сургууль, БГД-ын 102, Эрдмийн ундраа, Говь- Алтай, Хөвсгөл, Дорноговь, Өвөрхангай аймаг, Хэнтий аймгийн Баян-Адрага, Биндэр сумын сургуульд дээрх зөрчил ажиглагдаж байна.

2.39 Энэ бүхнээс үзэхэд хоол хүнс, ариун цэвэр хүнсний аюулгүй байдал, ариутгал халдваргүйтгэл хангалтгүй байна.


Орон нутагт бүтээгдэхүүний тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаж байна

2.40 Нийслэлд үдийн цайны бүтээгдэхүүн нийлүүлэгч аж ахуйн нэгжүүд сургуулиудад зориулалтын тусгай машинаар хүргэж, сургуулийн үдийн цай хариуцсан нярав хүлээн авч, тусгай зориулалтын өрөөнд хадгалж, тэндээсээ ангийн багш нар түгээж байна.

2.41 Гэвч орон нутагт бүтээгдэхүүний тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаж байна. Тухайлбал,

- Баянхонгор аймгийн сургуулиуд үдийн цайны бүтээгдэхүүнийг тээвэрлэх зориулалтын тээврийн хэрэгсэл байхгүйгээс замын машинаар авчирдаг, хадгалах зориулалтын тоног төхөөрөмж, өрөө байхгүй;
- Говь- Алтай аймгийн сумдад 7 хоногийн хэрэгцээг бөөнд нь хүргэж, олон хоног зориулалтын бус газар хадгалснаас зарим гурилан бүтээгдэхүүн хатаж, чанараа алдсан;
- Завхан аймгийн Ургамал, Дөрвөлжин, Баянтэс, Баянхайрхан, Цагаанхайрхан, Тэлмэн зэрэг сумын сургуулиуд 3-5 хоногийн бүтээгдэхүүнийг нөөцөлж, үдийн цайнд өгсөн;
- Булган, Өвөрхангай аймгийн зарим аж ахуйн нэгж хүнсний бүтээгдэхүүнийг зориулалтын бус машинаар хүргэсэн;
- Говьсүмбэр аймаг, Дорноговь аймгийн Өргөн, Хатанбулаг сумын сургууль бүтээгдэхүүнийг зориулалтын бус байранд, ундны усыг хуванцар саванд хадгалсан;
- Хэнтий аймгийн ихэнх сургууль, Орхон аймгийн Наранцогцолбор, 17, 18 болон хувийн хэвшлийн 3 сургуульд бүтээгдэхүүн хадгалах зориулалтын өрөөгүй,
- Хэнтий аймгийн сургуулиудад хөргөгч, хөлдөөгчийн хүрэлцээ дутмаг байна.

2.42 Санал асуулгад оролцогч багш нарын 21.6 хувь нь хадгалалтын горим зөрчигдсөн бүтээгдэхүүнийг хааяа өгдөг гэж үзсэн байна. Үүнийг графикаар харуулбал,



2.43 Хоол болон бүтээгдэхүүний дээж хадгалах хөргөгчгүй, байгаа боловч цантаж хөлдсөн, температур тодорхой бус, дээж хадгалалтын горим алдагдсан, дээжийн бүртгэл, устгалын дэвтэр хөтлөдөггүй сургуулиуд цөөнгүй байна. Тухайлбал,

- СХД-ийн Ирээдүй цогцолбор 1, 3 болон 107, БГД-ийн Эрдмийн ундраа 3 дугаар сургууль,
- Хэнтий аймагт дээжийг тогтмол авдаггүй, бүртгэлийг олон хоногоор хөтлөөгүй, дээж хадгалах горим алдагдсан зэрэг нийтлэг дутагдал гарсан,
- Хөвсгөл аймгийн Цэцэрлэгийн цогцолбор, Бүрэнхаан, Тариалан сумын сургуулиуд бүтээгдэхүүний дээж аваагүй,
- Дорноговь аймгийн Айраг, Иххэт сумын сургуульд дээжийн бүртгэл хөтлөөгүй,
- Хөвсгөл аймгийн нийт сургуулийн 36 хувь, Дундговь аймгийн сургуулиуд дээж хадгалах хөргөгчгүй,
- Сүхбаатар аймгийн ихэнх сумд, Дархан-Уул аймгийн хувийн сургуулиудад эмч ажиллахгүй байгаагаас үдийн цай олгох болон орчны эрүүл ахуйн байдалд тавих хяналт эзэнгүйдэж, хоол, бүтээгдэхүүнээс дээж авах, устгах ажиллагааг бүртгэх ажил хийгдээгүй байна.

2.44 Түүнчлэн сургуулиудад хүнсний болон ариун цэврийн тухай хууль, хоолны газрын нийтлэг журам зэрэг бусад эрх зүйн актын хэрэгжилт хангалтгүй байна.

Бүлэг 3

Хөтөлбөрийн хэрэгжилтийг хөдөлмөр эрхлэлт, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх төрийн бодлоготой уялдуулах боломж байна

Ерөнхий зүйл

3.1 2010 онд “Үдийн цай” хөтөлбөрт 271.7 мянган хүүхэд хамруулж, 17.3 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 257.7 мянган хүүхэд хамрагдаж 16.5 тэрбум төгрөг зарцуулсан нь боловсролын салбарын төсвийн 3.1 хувийг эзэлж байна.

3.2 Хөтөлбөрт зарцуулсан хөрөнгийн хэмжээг сүүлийн 5 жилээр графикаар харуулбал,



Ихэнх сургууль хүүхэд өдрийн гүйцэтгэлийг бодитой тооцдог, төрийн сангаас санхүүжилтийг гүйцэтгэлээр олгодог болсон байна

3.3 БСШУ-ны болон Сангийн сайдын 2009 оны 560/276 дугаар тушаалаар баталсан “Хүүхдийн цэцэрлэгийн хүүхдийн хоол, ерөнхий боловсролын сургуулийн үдийн цай (хоол), дотуур байрны хүүхдийн хоол, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, коллежид суралцагчдын тэтгэлэгийн зардлын

хэмнэлтийг тооцох, төвлөрүүлэх, зарцуулах журам”-ын дагуу зарим сургууль БСШУЯ-ны хэмнэлтийн дансанд үдийн цайны санхүүжилтийн үлдэгдэл 347.3 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

3.4 Харин Баян-Өлгий, Дорноговь, Дундговь, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгууд төвлөрүүлээгүй байлаа.

3.5 Аймаг, нийслэлийн БСГ-ууд хэмнэлтийн мэдээг нэгтгэж, БСШУЯ-д тогтоосон хугацаанд хүргүүлээгүй, яам ч улсын хэмжээний нэгтгэлийг СЯ-нд гаргаж өгөөгүй байна.

3.6 2010 онд үдийн цайны зардлаас хэмнэгдсэн мөнгөөр хөрөнгө худалдан авах, ойн арга хэмжээнд хандивлах, ажиллагсдын цалинд шилжүүлэх зэргээр зориулалт бусаар зарцуулдаг зөрчил бүрэн арилаагүй байна.

- Дорноговь аймгийн Хатанбулаг сум үлдэгдэл санхүүжилт 4.1 сая төгрөгөөр автомашин худалдан авсан,
- Булган аймгийн Рашаант сум 1794.6, Хутаг-Өндөр сумын Уньт багийн бага сургууль 366.0, Хантайн бага сургууль 205.0 мянган төгрөгийг цалинд олгосон,
- Дорнод аймгийн Хэрлэн сумын 11 дүгээр сургууль 747.9, Матад сумын сургууль 185.9, Халхгол сумын сургууль 70.0, Баянхонгор аймгийн Номундалай цогцолбор 620.1, Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын сургууль 1142.5, Сэлэнгэ аймгийн Хушаат сумын сургууль 1216.3 мянган төгрөгийг хүүхдийн дотуур байрны хоолонд шилжүүлэн зарцуулсан

3.7 Ихэнх сургууль хүүхэд өдрийн гүйцэтгэлийг бодитой тооцдог, төрийн сангаас гүйцэтгэлээр санхүүжүүлдэг болсон хэдий ч буруу тооцож илүү санхүүжилт авсан сургуулиуд цөөнгүй байна. Тухайлбал,

- Хэнтий аймгийн Биндэр сумын сургууль 449,4, Норовлин сумын сургууль 662.4, Бэрх тосгоны сургууль 743.7, Тэмүүжин цогцолбор сургууль 496.6, нийт 2801.5 мянган төгрөгийн санхүүжилт илүү авсан,
- Өвөрхангай аймгийн Сант сумын сургууль 2368, Арвайхээр сумын 2 дугаар сургууль 3858, Богд сумын сургууль 9468, Хархорин сумын 1 дүгээр сургууль 4229, 2 дугаар сургууль 2036, Арвайхээр сумын “Мэргэд” цогцолбор сургууль 656, “Оюуны-Ундраа” хувийн бага сургууль 12450 хүүхэд өдрөөр тус тус илүү тооцсоноос 9.4 сая төгрөг илүү олгосон тооцоо гарч байна.

Хөтөлбөрийг хөдөлмөр эрхлэлт, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх төрийн бодлоготой уялдуулах боломж байна

3.8 БСШУ-ны сайд, ЭМ-ийн сайдын 2006 оны 379/341 дүгээр тушаалаар батлагдсан “Үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд мөрдөх журам”-д хөтөлбөрийг хэрэгжүүлэх, гэрээт гүйцэтгэгчийг сонгоход баримтлах шалгуурыг тусгасан.

3.9 Уг журмын 1.3⁴ дахь заалт ихэнх сургуульд хэрэгжээгүй, аймгийн төвөөс алслагдсан зарим сум, багийн сургуулиуд үдийн цай нийлүүлэгчийг сонгох тендер зарлахад тухайн орон нутагт хүний нөөц, эрүүл ахуйн шаардлага хангасан байр, зориулалтын тоног төхөөрөмжтэй аж ахуйн нэгж цөөн байдгаас сонгон шалгаруулалт хийх боломж муу байна. Тухайлбал,

- Баянхонгор аймгийн Баянцагаан сумын сургуульд үдийн цай нийлүүлэгч “Утга нуур” ХХК гэрээ цуцлах хүсэлт гаргасан боловч бүтээгдэхүүн нийлүүлэх өөр компани байхгүйгээс хөтөлбөрийг үргэлжлүүлж байгаа;
- Орхон аймгийн Наран цогцолбор сургууль нийлүүлэгчийг шалгаруулахдаа “Бохирын цооног бэлтгэх” нэмэлт шаардлагыг тавьсанаас 2006 оноос хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж буй туршлага бүхий аж ахуй нэгжүүд сонгон шалгаруулалтад оролцохоос татгалзсан,
- Дорнод аймгийн Хэрлэн сумын 5, 6, 8, 11, Хан-Уул цогцолбор сургууль мах, хүнсний ногоог байнга нийлүүлэх аж ахуйн нэгж байхгүйгээс хувь хүмүүсээс худалдан авдаг,
- Говьсүмбэр аймагт аж ахуйн нэгж цөөн байгаагаас гол төлөв гурил мах, өндөг, будаа, зэрэгт эрүүл ахуйн шинжилгээний бичиг авч бусад зүйлийг өөрсдөө үнийн хямдыг бодож зах зээлээс бэлтгэдэг байна.

3.10 Нийслэлийн сургуулиудын эцэг эх, багш нарын төлөөлөл хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн үзэсгэлэн худалдаанаас мэдрэхүйн шалгалт хийснээр нийлүүлэгчийг сонгож, гэрээг улирал жилээр хийдэг боловч ихэнх сургуульд гэрээг дүгнэх явдал хангалтгүй байна.

⁴ Сургуулийн захирал аж ахуйн нэгжтэй байгуулах гэрээг 2-3 сарын хугацаатай байгуулж, гэрээний хэрэгжилтийг дүгнэсний /холбогдох хяналтын байгууллагын дүгнэлт/ үндсэн дээр сунгах эсэхээ хяналтын комисстой хамтран шийдвэрлэнэ ”

3.11 Зарим сургууль бэлтгэн нийлүүлэгчидтэй шууд гэрээ байгуулсан нь сонгон шалгаруулалт шударга, ил тод, нээлттэй, оролцогчдыг тэгш эрхээр хангасан гэх баталгаагүй, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөлийг бүрдүүлжээ. Тухайлбал,

- Хэнтий аймгийн Норовлин сумын сургуулийн захирал эхнэрийнхээ дэлгүүрээс бүтээгдэхүүнийхээ 60.8 хувийг, Мөнххаан сумын сургуулийн захирал төрөл садангийнхаа хүний аж ахуйн нэгжээс 100 хувь авдаг.
- Архангай аймгийн Ихтамир, Математик сургуулиуд захирлынхаа, Хотонт, Хангай, Цэнхэр сумд, Ирээдүй сургуулиуд нягтлан бодогчийнхоо аж ахуйн нэгжээс авдаг,
- Орхон аймгийн Жаргалант сумын сургууль гурилан бүтээгдэхүүн, махан хоолыг иргэнтэй шууд гэрээ байгуулан 2 ширхэг буузыг 500 төгрөгөөр авч байгаа нь ЗГ-ын 2008 оны 45 дугаар тогтоолд өдөрт 400 төгрөгөөр тооцно гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.12 Тухайн сум орон нутагт хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр зээл авсан аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг “Үдийн цай” хөтөлбөр, сургуулийн дотуур байр, цэцэрлэгийн хүүхдийн хоол болон ард иргэдийн хүнсний хангамжтай холбож, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх төрийн бодлоготой уялдуулах чиглэл баримталж ажиллах шаардлагатай байна.

Олон улсын жишээ:

“Сургуулийн үдийн хоолны тухай” хуулийг АНУ 1946 онд, Япон Улс 1954 онд, БНСУ 1981 онд тус тус баталсан бөгөөд дотоодын бүтээгдэхүүн тэр дундаа орон нутгийн газар тариалангийн бүтээгдэхүүнийг хэрэглэхийг заажээ⁵.

Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй аж ахуйн нэгжид хариуцлага тооцоогүй байна

3.13 Дархан-Уул аймагт “Дархан хүнс”, “Поликом”, “Мөнх-Ундрам хүнс”, “Дархан сондор трейд”, “Дархан дээжис” ХХК-иудтай 2006 онд гэрээ хийсэн нь одоог хүртэл хэрэгждэг, бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ өөрчлөгдсөн, хугацаа дууссан байхад дахин шинэчлээгүй, цайны газар түрээслэдэг 11 аж ахуйн нэгжээс зарим нь гэрээний хугацааг хичээлийн жилээр хийсэн байна.

3.14 Гэрээний хэрэгжилтийг дүгнэх, хариуцлага тооцох явдал хангалтгүй байна. Тухайлбал,

- Дархан-Уул аймгийн 4, 22, Жигүүр цогцолбор сургуулиуд гэрээг 9 сарын хугацаатай хийсэн боловч гэрээний хэрэгжилтийг дүгнээгүй, зарим гэрээний хугацаа, бүтээгдэхүүний үнэ, өртөг, илчлэг, эрүүл ахуйн шаардлага, гэрээг сунгах, хариуцлага тооцох нөхцөл тодорхой бус,
- Дорноговь аймгийн Хөвсгөл, Улаанбадрах, Иххэт, Алтанширээ сумдын сургууль гэрээг бүтэн жилээр хийж, гэрээний үүргийн биелэлтийг дүгнээгүй,
- Баянхонгор аймгийн Эрдэм сургуульд бүтээгдэхүүн нийлүүлэгч “Тосуйн гол” ХХК-д зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн боловч биелэлтийг тооцоогүй, Соого сейкео сургууль “Их тэнгэрийн хүч” ХХК-тай 3 удаа хариуцлага тооцсон гэх боловч баримтгүй,
- Дорноговь аймгийн Сайншанд сумын 2 дугаар сургууль “Арвижих” цехтэй 50 грамм жинтэй “Навчит булочка”-ыг 150 төгрөгөөр худалдан авахаар гэрээ хийснийг 10 ширхгийг жинлэж үзэхэд хэмжээндээ хүрэхгүй 8-10 граммаар дутуу байсан.


⁵ БСШУЯ, ШУТИС-ийн Хүнс, биотехнологийн сургуулийн харьяа шим тэжээл судлалын төвөөс “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн хамтарсан судалгааны тайлан

3.15 Бүтээгдэхүүн үйлдвэрлэдэггүй хэрнээ хүнсний дэлгүүр болон үйлдвэрлэгчээс худалдан авч, үдийн цайнд дамжуулан нийлүүлж байгаа нь журмын 1.4⁶-ийг зөрчсөн бөгөөд эрсдэл гарсан тохиолдолд хариуцлагыг эзэнгүйдүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна.Тухайлбал,

- Увс аймгийн Тариалан, Давст сумдад сумын төвийн хүнсний дэлгүүр шалгарч үдийн цайны бүтээгдэхүүнийг Улаангом хотын үйлдвэрүүдээс авч нийлүүлж,
- Улаанбаатар хотод Талх чихэр ХК-ийн бүтээгдэхүүнийг Том бат ХХК сургуулиудтай гэрээ байгуулан нийлүүлж байна.

Зарим сургууль хяналтын комисс байгуулаагүй байна

3.17 Холбогдох эрх зүйн актаар “Үдийн цай” хөтөлбөрийн дотоод хяналтыг дараахь байдлаар тодорхойлжээ.



3.18 Ихэнх сургуулийн хяналтын комисс болон сургуулийн эмч, бага ангийн сургалтын менежер, багш нар үдийн цайнд нийлүүлэгдэж буй бүтээгдэхүүн, хоолонд өдөр тутмын хяналтыг мэдрэхүйн шалгалтаар хийж тэмдэглэл хөтөлж байна.

3.19 Хөвсгөл аймгийн Тариалан, Бүрэнтогтох сумдын сургуулийн хяналтын комиссын гишүүн бус эцэг эхийн зүгээс зөвлөл байгуулан ажиллаж байгаа нь бусад сургуулиудын хувьд үлгэр жишээ болох хөндлөнгийн хяналт байв.

3.20 Сургуулиудад хяналтын комисс, аймаг, нийслэлийн БСГ-т орон тооны бус хяналтын зөвлөл ажилласнаар хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих дотоод хяналт сайжирч, хүүхэд өдрийн гүйцэтгэл бодитой болсон зарим ахиц гарсан байна.

⁶Үдийн цайны бүтээгдэхүүнийг гэрээт борлуулагчаар дамжуулах, хувь хүнээс худалдан авахыг хориглоно

3.21 Гэвч Хэнтий аймгийн Баян-Адрага, Баянхонгор аймгийн Эрдэнэцогт, Баянцагаан, Төв аймгийн Баян-Өнжүүл, Баянхангай сумдын ЕБС, Архангай аймгийн “Гурван тамир”, “Математик”, “Билгүүн” зэрэг төрийн бус сургуулиуд хяналтын комисс байгуулаагүй байна.

3.22 Зарим сургуулийн хяналтын комисс зохих түвшинд хяналт тавьж байгаа ч хийсэн ажлаа баримтжуулаагүй, эцэг эхчүүд, ангийн багш болон сургуулийн захиргаанд танилцуулж тайлагнаагүй, ажлын үнэлэлт, дүгнэлт хангалтгүй байна. Тухайлбал,

- *Завхан, Баян-Өлгий, Өмнөговь, Өвөрхангай, Ховд, Говь-Алтай Дорноговь, Баянхонгор, Дундговь аймгийн зарим сургууль, Төв аймгийн Сүмбэр, Эрдэнэсант, Дэлгэрхаан, Заамар сум, Сүхбаатар аймгийн Халзан, Түвшинширээ, Уулбаян, Мөнххаан сумдын сургууль болон УБ хотын СБД-ийн ихэнх сургуулийн хяналтын комиссыг дурдаж болно.*

Олон улсын жишээ:

АНУ, ИБУИНВУ болон Гонконгд үдийн хоолыг хэрхэн олгох талаар эхлээд гарын авлага гаргаж эцэг эхчүүдэд танилцуулдаг, дараа нь эцэг эхчүүдээр улирал болгон санал авах хуудас бөглүүлдэг, хоол бэлтгэн нийлүүлэгчдэд гарын авлага өгч хоолоо яаж бэлтгэх, илчлэг, тэжээллэг зэргийг тооцоолсон стандарт гаргаж, эрүүл ахуйн шаардлага хангасан эсэх, тоног төхөөрөмжийн хангамжийн талаар дурьдаж өгсөн байдаг байна.

Орон нутагт мэргэжлийн байгууллагууд хяналтаа хамтран хэрэгжүүлж байна

3.23 БСШУ-ны болон ЭМ-ийн сайдын 2006 оны 379/341 дүгээр тушаалаар баталсан “Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд мөрдөх журам”-д⁷ заасны дагуу МХГ,ЭМГ, БСГ зэрэг холбогдох мэргэжлийн байгууллагууд хөндлөнгийн хяналтыг хамтарсан хэлбэрээр хэрэгжүүлж байна.

3.24 Зарим аймагт төрийн бус байгууллага болон олон улсын байгууллагуудтай хамтарсан сургалт зохион байгуулж, хөтөлбөрийн хэрэгжилтэд мониторинг хийсэн байна.Тухайлбал,

- *Ховд, Увс, Говь-Алтай, Завхан, Баянхонгор аймаг, Дундговь аймгийн Сайнцагаан сумын 3-р сургууль, Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын сургууль, Баруун-Урт сумын Д.Сүхбаатарын нэрэмжит сургууль хөтөлбөрийн хэрэгжилтэд мониторинг үнэлгээ хийлгэж, Мерси Кор ОУБ, Норвегийн тусламжийн ОУБ, Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн холбоо ТББ-уудтай хамтран аймгийн бүх сургуулиудын захирал, бага ангийн сургалтын менежер, эмч, дотуур байрны багш, тогооч, эцэг эхийн хяналтын зөвлөлийн дарга, гишүүд, бэлтгэн нийлүүлэгч аж ахуйн нэгжүүдийн төлөөлөл, сумын ХАА-н мэргэжилтэн нарт сургалт, семинар зохион байгуулсан байна.*


3.25 Гэвч зарим аймгийн мэргэжлийн байгууллага болон хяналтын зөвлөл хангалтгүй ажиллаж байна.Тухайлбал,

- *Дундговь аймгийн ЭМГ “Үдийн цай” хөтөлбөрийн талаар төлөвлөгөө хөтөлбөртөө оруулаагүй, хяналт шалгалт хийгээгүй,*
- *Баянхонгор, Өмнөговь аймгийн орон тооны бус хяналтын зөвлөл 2010-2011 онд батлагдсан ажлын төлөвлөгөөгүй,*
- *Архангай аймгийн орон тооны бус хяналтын зөвлөл тодорхой ажил хийгээгүй байна.*

⁷ 6.1.“Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилтэд аймаг нийслэлийн ЭМ-ийн болон БСГ, мэргэжлийн хяналтын байгууллага хамтран хяналт тавина

БСШУЯ хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийгээгүй байна

3.26 Холбогдох эрх зүйн актаар “Үдийн цай” хөтөлбөрийн тайлагналыг дараахь байдлаар тодорхойлжээ.



3.27 “Орон тооны бус хяналтын зөвлөл байгуулах тухай” БСШУ-ы сайдын 2010 оны 45 дугаар тушаалын 5 дугаар заалтаар ⁸ хяналтын зөвлөлүүдийн тайланг тус яаманд ирүүлдэг байна.

3.28 БСШУ-ны сайдын 2006 оны 301 дүгээр тушаалын 4 дүгээр заалт ёсоор ⁹ “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн, жил бүр хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж ажиллах ёстой атал 2010 онд хийгдээгүй байна.

Олон улсын жишээ:

БНСУ сургуулийн хоолны үйлчилгээг хэд хэдэн үе шатаар шинэчлэн зохион байгуулсан байна. Эхний үе шатанд гадаад орны тусламжид тулгуурлан зохион байгуулж байгаад 1990 оноос хойш гадаадын тусламж, төр, засгаас санхүүжүүлэхийг багасгаж, эцэг эхийн санхүүжилтэд тулгуурлах зарчмыг баримтлан холбогдох хууль, эрх зүйн үндсийг бүрдүүлж, сургууль дээр хоолны үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн зохион байгуулах болжээ.

⁸ Аймаг дүүргийн хэмжээнд авч хэрэгжүүлж буй ажлын тайланг улирал бүр БСШУЯ-д ирүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн БСГ-ын дарга нарт даалгасугай

⁹ “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн танилцуулж, үр дүнд жил бүр хяналт, -шинжилгээ, үнэлгээ хийж хөтөлбөрийн хүрээнд гарсан асуудлыг зохицуулж ажиллахыг Бага, дунд боловсролын газар, Санхүү-эдийн засгийн газар, Мэдээлэл, хяналт шинжилгээ үнэлгээний газарт тус тус даалгасугай

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна. Үүнд:

1. “Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлага, нөхцөл шалтгаан зорилго, зорилт гарах үр дүнг тодорхойлж, албан ёсны бичиг баримтыг боловсруулалгүйгээр улсын хэмжээнд шууд эхлүүлсэн нь **нэгдсэн зохицуулалт**, чанар стандартын горим алдагдахад нөлөөлжээ.
2. “Үдийн цай” хөтөлбөрийг “Үдийн хоол” болгон өргөжүүлэх нөхцөл боломж бүрдээгүй, хүнсний бүтээгдэхүүнийг шинжилгээнд бүрэн хамруулах боломж хомс, хооллох орчин, хоол үйлдвэрлэх гал тогоо, тоног төхөөрөмж, мэргэжилтэй боловсон хүчин дутмаг байна.
3. “Үдийн цай хөтөлбөрт хамаарах шаардлагатай нэгдсэн **цэс, технологийн карт**, стандарт байхгүй, одоогийн мөрдөж буй журам шаардлага хангахгүй болсон байна.
4. Хөтөлбөрийн үр дүнд сурагчдын хичээлийн ирц, сурах идэвхи сайжирч, сургууль завсардалт тодорхой хэмжээгээр буурч, өрхийн амьжиргаанд тус дэм болж байгаа нь судалгаа, санал асуулгын дүнгээс харагдаж байгаа боловч сурлагын чанар, хүүхдийн өсөлт, хөгжил, эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөллийг тооцох боломжгүй байна.
5. Хөтөлбөрийн хэрэгжилтэд төрийн байгууллагуудын оролцоог тодорхойлсон эрх зүйн акт хангалтгүй, тэдний ажлын уялдаа холбоо, мэдээллийн солилцоо ч дутмаг байна.
6. Орон нутагт бүтээгдэхүүн нийлүүлэгчтэй шууд гэрээгээр худалдан авалт хийсэн, гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн аж ахуйн нэгжид хариуцлага тооцоогүй байна. Энэ нь алслагдсан сум, багт шаардлага хангасан аж ахуйн нэгж ховор байгаатай зарим талаар холбоотой бөгөөд иймд жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх төрийн бодлоготой уялдуулах шаардлагатай байна.

БСШУЯ-ны санал



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОР Ч.РАДНАА ТАНАА

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,
Утас: 26-24-80, Факс: 32-31-58, 26-06-13

E-mail: mecs@mecs.gov.mn, http://www.mecs.gov.mn/

2011.09.06 № 1а/1841

танай _____-ны № _____-т

Аудитын дүгнэлтэд санал
өгөх тухай

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах талаар санал, зөвлөмж өгч хамтран ажиллаж буйд талархаж байна.

“Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2008 оны 35 дугаар тогтоолын 1.2-ийн 1.2.7-д “Үдийн цай хөтөлбөрийг үдийн хоол болгон өргөжүүлнэ” гэж заасан.

Засгийн газраас ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоолны үйлчилгээг бий болгох зорилтыг хэрэгжүүлэхдээ сургуулийн хоол, хүнсний аюулгүй байдлын баталгааг бүрдүүлэх, үйлчилгээг нэвтрүүлэх бэлэн байдлыг хангах үндсэн дээр үе шаттайгаар нэвтрүүлэх бодлогыг баримталж байна.

Засгийн газрын 2011 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдааны 21 дүгээр тэмдэглэл, “Хөтөлбөрийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын тухай” Засгийн газрын 2011 оны 179 дүгээр тогтоолын дагуу Концессийн зарчмаар Улаанбаатар хотод 15000 хүүхдийн хүчин чадалтай хоол, хүнсний эхний комбинатыг барьж, 2012 онд ашиглалтад оруулахаар уралдаант шалгаруулалтыг зохион байгуулах, ерөнхий боловсролын сургуульд үдийн хоолны үйлчилгээг үе шаттай нэвтрүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, хүний нөөцийн чадавхийн бэлтгэлийг хангах, хоол хүнсний үйлчилгээний технологи, аюулгүй байдлыг хангахтай холбоотой дүрэм, журмыг боловсруулах ажлыг эхлүүлээд байна.

Дээрх ажлыг хэрэгжүүлэхэд аудитын дүгнэлтэд туссан зүйлүүдийг анхаарч ажиллах болно.

Хүндэтгэсэн,

САЙД



Е.ОТГОНБАЯР

904 64

ХХААХҮЯ-ны санал



МОНГОЛ УЛСЫН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайваны өргөн чөлөө 16а, Засгийн газрын IX байр,
Утас: 26-22-71, Факс: (976-11) 45-31-21,
E-mail: mofa@mofa.gov.mn; http://www.mofa.gov.mn

2011.08.29 № 1/2580
танай 2011.08.25-ны № 642 -Т

642 тоот албан бичгийн хариу

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОР Ч.РАДНАА
ТАНАА

УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны Байнгын хорооны саналаар Үндэсний аудитын газрын “Үдийн цай” хөтөлбөрийн явц, үр дүнд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцан дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Уг тайлангийн 2 дугаар бүлгийн 2.27-д “... чихэрлэг гурилан бүтээгдэхүүн, жимсний шүүс давамгайлсан, сүү цагаан идээ, жимс жимсгэнэ бага ...” гэжээ. Олдоц болон үнийн хувьд боломжтой, хүүхдийн бие махбодийн онцлогт тохирсон, амин дэм, эрдсээр баялаг бүтээгдэхүүн бол чацаргана болон үзэмний шүүс юм. Засгийн газрын 2010 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 60 дугаар тогтоолоор баталсан “Чацаргана” үндэсний хөтөлбөр нь чацарганыг аж ахуй болон өрхийн тариалалтын чиглэлээр 20 мян.га хүртэл талбайд тариалж, цөлжилтөөс сэргийлэх, хөрс, байгаль орчныг хамгаалах, хүн амыг амин дэм бүхий жимс жимсгэнээр тогтвортой хангах зорилготой тул “Үдийн цай” үндэсний хөтөлбөртэй уялдуулж, сурагчдад үйлдвэрийн аргаар бэлтгэсэн, чанар, эрүүл ахуйн шаардлага хангасан чацаргана болон бусад жимсний шүүс тогтмол өгөх ажлыг зохион байгуулах талаар зөвлөмжид тусгах;

2. “Хүнсний аюулгүй байдал” үндэсний хөтөлбөрийн 22.5 дахь заалтад тусгасан “Үдийн цай” хөтөлбөрийн хүрээнд олгож байгаа хүнсний тэжээлэг чанар, аюулгүй байдлыг сайжруулж, 60-аас доошгүй хувьд сүү цагаан идээ хэрэглэдэг болох зорилтыг хэрэгжүүлэхийн тулд дотоод, гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламжийг хүүхдийн нэг удаагийн хооллолтонд тохируулан савласан сав баглаа бүхий сүү, тараг, ааруул, аарц үйлдвэрлэх үйлдвэрлэлийг, ялангуяа орон нутгийн жижиг дунд үйлдвэрийг дэмжихэд чиглүүлэх талаар зөвлөмжид тусгах;

3. “Үдийн цай” хөтөлбөрт хамрагдаж буй сурагчдад эрүүл мэндийн үзлэг хийж, шүд цоорох өвчин болон ясны сийрэгжилтийг үдийн цайнд олгож буй бүтээгдэхүүнтэй уялдуулан судлах талаар зөвлөх.

ҮАГ-ын тайлбар
2-ыг үзнэ үү

ҮАГ-ын тайлбар
3-ыг үзнэ үү

ДЭД САЙД  Ж.САУЛЕ



Төм нөөц 2011.04

00803870

ҮАГ-ын тайлбар

ХХААХҮЯ-ны саналд:

Тайлбар 1:Саналыг хүлээн авч зөвлөмж 2-т нэмэлт өөрчлөлт оруулав.

Тайлбар 2:Саналыг хүлээн авч зөвлөмж 2-т нэмэлт өөрчлөлт оруулав.

Тайлбар 3:Саналд тусгагдсан асуудлыг энэ удаагийн аудитаар тусгайлан судлаагүй тул зөвлөмж өгөх боломжгүй.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаярт:

1. “Үдийн цай” хөтөлбөрийг “Үдийн хоол” болгон өргөжүүлэхийн өмнө мэргэжлийн байгууллагын оролцоотой нарийвчилсан тооцоо судалгаа хийх, урьдчилсан нөхцөл бүрдүүлэх арга хэмжээ авах;
2. Сурагчдад хичээлийн завсарлагаар цай, хоолоор үйлчлэх ажлыг албан ёсны батлагдсан хөтөлбөртэй болгох, түүний талаар нэгдсэн стандартыг “Хүнсний аюулгүй байдал”, “Чацаргана” зэрэг Үндэсний хөтөлбөрүүдэд нийцүүлэн боловсруулж батлуулах, “Үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд мөрдөх журам”-ыг өнөөгийн нөхцөлд нийцүүлэн бүс орон нутгийн онцлогыг харгалзан боловсронгуй болгох;
3. “Үдийн цай” хөтөлбөрийн хүрээнд сурагчдад олгож байгаа хоол хүнсийг шинжилгээнд бүрэн хамруулах арга хэмжээ авах;
4. “Үдийн цай” хөтөлбөрийн талаарх мэдээллийн нэгдсэн сантай болох, улмаар хөтөлбөрийн үр дүнд хүүхдийн сурлага, эрүүл мэнд, өсөлт хөгжил зэрэгт хэрхэн нөлөөлж байгааг тооцох үзүүлэлт, аргачлалыг боловсруулж хэрэгжүүлэх;
5. Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтэд оролцогч талуудын хүлээх үүргийг тодорхой болгож, хамтын ажиллагааг дэмжих санал боловсруулж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунайд:

1. Сум, орон нутагт хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр зээл авсан аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг “Үдийн цай” хөтөлбөр, сургуулийн дотуур байр, цэцэрлэгийн хүүхдийн хоол болон ард иргэдийн хүнсний хангамжтай холбож, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх төрийн бодлоготой уялдуулах арга хэмжээ авах.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2011 оны 9 сарын 9 өдөр

Дугаар 81

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

“Төрийн аудитын тухай хууль”-ийн 13.4.5, “Гүйцэтгэлийн шалгалтын журам”-ын 23.2, “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. “Үдийн цай” хөтөлбөрийн явц, үр дүнд хийсэн аудитын тайланг баталсугай.
2. Аудитын тайланг Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны Байнгын хороо, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2012 оны 6 дугаар сарын 1-ний дотор ҮАГ-т ирүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай нарт зөвлөсүгэй.
4. Аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газрын захирал Д. Ганбилэгт үүрэг болгосугай.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Ч.Раднаа

Ч.РАДНАА

070018
Mishan